



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2022 оны 04 сарын 01 өдөр

Дугаар А/169

Хэрлэн сум

Тээврийн хэрэгслийн татвар хураалт,  
техникийн хяналтын үзлэг явуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн хэмжээнд авто тээврийн хэрэгслийн татвар хураалтыг 2022 оны 6 дугаар сарын 01-ний дотор, техникийн хяналтын үзлэгийг жилийн туршид зохион байгуулсугай.

2. Дээрх ажлыг зохион байгуулах комиссыг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Комиссын дарга:	Л.Батсайхан	Аймгийн Засаг даргын орлогч
Нарийн бичгийн дарга:	Ц.Бат-Эрдэнэ	Аймгийн Автотээврийн төвийн дарга
Гишүүд:	Э.Мөнх Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
	А.Гантөмөр	Аймгийн Татварын хэлтсийн дарга
	Д.Батхүү	Хэнтий аймаг дахь Цагдаагийн газрын дарга, Цагдаагийн хурандаа

3. Сумдад авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэг явуулах хуваарийг 1 дүгээр хавсралтаар, ажлын удирдамжийг 2 дугаар хавсралтаар тус тус баталсугай.

4. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгийг өөрийн нутаг дэвсгэрт байгаа бүх тээврийн хэрэгслийг бүртгэл судалгааны дагуу бүрэн хамруулах, техникийн үзлэгийн өмнө авто тээврийн хэрэгслийн албан татварыг хураан авах ажлыг зохион байгуулсан байхыг сум, багийн Засаг дарга нарт, хуваарьт өдрүүдэд хэв журам сахиулах ажилтнуудыг үүрэгжүүлж, хариуцлагатай

2.

ажиллуулахыг аймаг дахь Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Д.Батхүү)-д тус тус үүрэг болгосугай.

5. Сумдад батлагдсан хуваарийн дагуу явагдсан авто тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгт ороогүй тээврийн хэрэгслийг замын хөдөлгөөнд оролцохыг хориглох, зөрчлийг арилгуулах арга хэмжээ авч ажиллахыг аймаг дахь Цагдаагийн газрын дарга (Цагдаагийн хурандаа Д.Батхүү)-д, техникийн хяналтын үзлэгээс хоцорсон тээврийн хэрэгслийг техникийн үзлэгт тухай бүрд нөхөн оруулж байхыг Автотээврийн төвийн дарга (Ц.Бат-Эрдэнэ)-д тус тус даалгасугай.

6. Тээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэгийн үйл ажиллагааг хагас бүтэн жилээр дүгнэн, дүнг танилцуулахыг комиссын дарга (Л.Батсайхан)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ

Аймгийн Засаг даргын 2022 оны  
 04 дугаар сарын 01 өдрийн  
 захирамжийн нэгдүгээр хавсралт

ХЭНТИЙ АЙМГИЙН АВТОТЭЭВЭ ИЙН ТӨВИЙН ОРОН НУТАГТ  
 ТЕХНИКИЙН ХЯНАЛТЫН ҮЗЛЭГИЙГ ЯВУУЛАХ ХУВААРЬ

№	Сумдууд	Явах хоног	сар өдөр	Ажлын бүрэлдэхүүн
01.	Бор-Өндөр УБҮ	1	04 сарын 18	Техникийн үзлэгийн Б.Баярмагнай  Техникийн үзлэгийн С.Наранхүү
	Бор-Өндөр	6	04 сарын 19 - 04 сарын 24	
	Дархан	2	04 сарын 25 - 04 сарын 26	
	Баянмөнх	2	04 сарын 27 - 04 сарын 28	
	Галшар	2	04 сарын 29 - 04 сарын 30	
02	Хэрлэн сум	5	05 сарын 02 - 05 сарын 06	
	ХБУлаан	1	05 сарын 09	
	Дэлгэрхаан	2	05 сарын 10 - 05 сарын 11	
	Цэнхэрмандал	4	05 сарын 12 - 05 сарын 15	
	Жаргалтхаан	3	05 сарын 16 - 05 сарын 18	
	Өмнөдэлгэр	4	05 сарын 19 - 05 сарын 22	
03.	Хэрлэн сум	5	05 сарын 23 - 05 сарын 27	
04.	Баянхутаг	2	05 сарын 30 - 05 сарын 31	
	Мөрөн	2	06 сарын 02 - 06 сарын 03	
	Өлзийт	1	06 сарын 06	
	Хурх	1	06 сарын 07	
	Батширээт	2	06 сарын 08 - 06 сарын 09	
	Биндэр	4	06 сарын 10 - 06 сарын 13	
	Баян адрага	2	06 сарын 14 - 06 сарын 15	
	Дадал	4	06 сарын 16 - 06 сарын 19	
	Норовлин	2	06 сарын 20 - 06 сарын 21	
	Баяновоо	2	06 сарын 22 - 06 сарын 23	
	Батноров	3	06 сарын 24 - 06 сарын 26	
	Бэрх	2	06 сарын 27 - 06 сарын 028	
	Тахилгат	1	06 сарын 29	
	Орон нутагт	55		



Аймгийн Засаг даргын 2022 оны  
дугаар сарын 01-ны өдрийн  
захирамжийн хоёрдугаар хавсралт

## **Хэнтий аймгийн автотээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг явуулах ажлын удирдамж**

### **Нэг. Зорилго:**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татварын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 7 дугаар зүйлийн 7.1, Авто тээврийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1, 17.2 дахь заалтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

### **Хоёр. Хугацаа:**

Сумдад автотээврийн хэрэгслийн татвар хураалт, техникийн хяналтын үзлэг явуулах ажлыг 2022 оны 4 дүгээр сарын 18-аас эхлэн 2022 оны 6 дугаар сарын 29-ийг хүртэл

### **Гурав. Хэрэгжүүлэгч байгууллага:**

1. Хэнтий аймгийн Автотээврийн төв  
Хамтран хэрэгжүүлэгч байгууллагууд:
1. Хэнтий аймгийн Засаг даргын Тамгын газар
  2. Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар
  3. Хэнтий аймгийн Татварын хэлтэс
  4. Сумдын Засаг даргын Тамгын газар

### **Дөрөв. Хэрэгжүүлэх арга хэмжээ:**

Хэнтий аймгийн Автотээврийн төв:

1. Аж ахуйн нэгж байгууллагуудын ажлын ачаалал, тээврийн хэрэгслийн тоог харгалзан хуваарь гарган оны эхний улиралд хамруулах;
2. Ажлын хэсгийн ахлагч нь сумын удирдлагатай уулзан бэлтгэл зохион байгуулалттай танилцаж, сумын комисстой хамтран ажиллана. Батлагдсан хуваарийн дагуу техникийн хяналтын үзлэгийг явуулж, дүнгийн хурал хийж татвар төлөлт, үзлэгт хамрагдсан байдал, сумын комиссын үйл ажиллагаанд үнэлэлт өгч, тэмдэглэл хөтөлнө;
3. Тээврийн хэрэгслийг нэг бүрчлэн бүртгэл хөтөлөн суурин болон зөөврийн тоног төхөөрөмжөөр хяналт үзлэг хийж тэнцсэн тохиолдолд тээврийн хэрэгслийн гэрчилгээнд тэмдэглэл хийж гэрчилгээ олгоно;
4. Тээврийн хэрэгслийн өмчлөгч жолоочийн даатгалд даатгуулаагүй, авто тээврийн татвар, төлбөр хураамж төлөөгүй тохиолдолд тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт оруулахгүй байх

Сумдын Засаг даргын Тамгын газар:

1. Сумын Засаг даргын захирамжаар комисс томилж бэлтгэл ажлыг хангана;
2. Сумын комисст татварын байцаагч, багийн Засаг дарга нар, цагдаагийн ажилтан, үүрэг бүхий бусад хүмүүсийг оролцуулна;
3. Хуваарьт өдөр комисс ажиллах нөхцөлийг бүрдүүлж, техникийн хяналтын үзлэг явуулах байр, талбай, жолоочийн албан журмын даатгалын компаниудын ажиллах байрын бэлэн байдлыг хангах;

4. Тээврийн хэрэгсэл эзэмшигчдийг баг, байр, хэсгүүдээр нь хуваарь гаргаж үзлэгт, хамрагдах өдрийг урьдчилан зарлаж гарын үсгээр баталгаажуулсан байна;

Аймгийн Татварын хэлтэс:

1. Татвар хураалтыг урьдчилан зохион байгуулсан байна;

2. Сумд дахь татварын байцаагч нь багийн Засаг дарга нарын бүртгэлийг сумын хэмжээний нийт тээврийн хэрэгслийн нэгдсэн бүртгэлтэй тулган татвар төлөлтөд хяналт тавьж, үзлэгт орсон тээврийн хэрэгслийн тоотой тулгалт хийн татварын орлогын дүнг нэгтгэн гаргаж комисст илтгэнэ;

Хэнтий аймаг дахь Цагдаагийн газар:

1. Сумын цагдаагийн тасаг, хэсгийн төлөөлөгч техникийн үзлэг, явагдах хуваарьт өдрүүдэд, комиссын бүрэлдэхүүнд ажиллан хөдөлгөөн зохицуулах, зогсоол талбайд байрлуулах, дэг журам сахиулах ажлыг гүйцэтгэнэ;

2. Комиссын бүрэлдэхүүн ажиллах өдрүүдэд үзлэгт хамрагдаж байгаа тээврийн хэрэгсэл эзэмшигч нарт туслах, комиссын ажлыг дэмжиж ажиллах;

3. Хуваарьт хугацаанд үзлэгт ороогүй буюу урьд жилийн хугацаа хэтэрсэн тээврийн хэрэгсэл эзэмшигчид хариуцлага тооцох, тээврийн хэрэгслийн гэрчилгээг Автотээврийн төвд шилжүүлэн техникийн хяналтын үзлэгт хамруулах ажлыг хамтран зохион байгуулан ажиллана;

4. Авто тээврийн хэрэгслийн техникийн хяналтын үзлэгт ороогүй, авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар төлөөгүй, жолоочийн даатгалд даатгуулаагүй тээврийн хэрэгслүүдийг замын хөдөлгөөнд оролцуулахгүй байх